



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.10 дахь заалт, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2023 оны 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дундговь аймгийн өмчөөс шилжүүлсэн, 7,500,000.00 (долоон сая таван зуун мянга) төгрөгийн балансын үнэ, 1,125,000.00 (нэг сая нэг зуун хорин таван мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Дундговь аймгийн Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Адъяасүрэн, Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Доржбат, Дундговь аймгийн Төрийн аудитын газрын дарга Р.Мөнхтогтох нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулж, данс бүртгэлд тусгах засаж, сэлбэн ашиглах ажлыг зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123007537
1-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 01 дүгээр сарын 1-ны өдрийн
10... дугаар тогтоолын хавсралт



Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн
хөрөнгөд бүртгэлтэй Дундговь аймгийн Төрийн аудитын газарт
балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Архивын нягтруулсан шүүгээ	2022/ 2022	7,500,000.00	1,125,000.00	6,375,000.00
	Нийт дүн		7,500,000.00 (долоон сая таван зуун мянга)	1,125,000.00 (нэг сая нэг зуун хорин таван мянга)	6,375,000.00 (зургаан сая гурван зуун далан таван мянга)